

БАТЛАВ
ДУНДГОВЬ АЙМГИЙН ХЭЛНИЙ БОДЛОГЫН
САЛБАР ЗӨВЛӨЛИЙН НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА *Ц.Уранбямба* Ц. УРАНБЯМБА



**“ҮНДЭСНИЙ БИЧИГ ҮСГИЙН БАЯР-2022” АЯНЫ ХҮРЭЭНД ЗОХИОН БАЙГУУЛАХ “
БИЙРИЙН БИЧИГ”-ИЙН УРАЛДААНЫ УДИРДАМЖ**

Мандалговь

2022. 04.05

НЭГ. ҮНДЭСЛЭЛ: Монгол улсын тухай хуулийн 17.1.3, 20.1.1 дугаар заалт, Монгол улсын ерөнхийлөгчийн 2003 оны 10-р зарлиг, Засгийн газрын 2020 оны 03-р сарын 18-ны өдрийн 96 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол бичгийн үндэсний хөтөлбөр” зэрэг нь энэхүү уралдааныг зохион явуулах эрх зүйн үндэс болно.

ХОЁР. ЗОРИЛГО: Дундговь аймгийн хүүхэд багачуудын эх хэл, бичиг соёлоо сурч судлах, хамгаалах, хөгжүүлэх, өвлөх үйл хэрэгт оруулах хувь нэмэр оролцоог нэмэгдүүлэх, монгол бичгийн боловсролыг дээшлүүлэх, бийрээр бичих сонирхолтой хүүхэд багачууд, иргэдийн сонирхлыг дэмжих, урамшуулах

ГУРАВ. ХАМРАХ ХҮРЭЭ: ЕБС-ийн дунд, ахлах ангийн сурагчид

ДӨРӨВ. ЗОХИОН БАЙГУУЛАГЧ: Дундговь аймгийн БШУГ, ГИЦС

ТАВ. ЗОХИОН БАЙГУУЛАХ ГАЗАР, ХУГАЦАА: 2022 оны 04 сарын 23-нд ГИЦС-ийн зааланд болно.

ЗУРГАА. УРАЛДААНЫ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ: Уралдаан нь дунд ба ахлах ангийн сурагчид гэсэн хоёр ангиллаар болно. Оролцох сурагчдын тоо хязгаарлахгүй.

- Уралдаанд оролцогчид зохион байгуулагчдын бэлдсэн бичвэрийг тогтсон хугацаанд бичнэ.
- Уралдааны бүтээлийг бичих ур чадвар, зохиомж, сэтгэлгээг харгалзан үнэлнэ.
- Оролцогчид бичгийн хэрэгслээ өөрсдөө бэлдэж ирнэ. /муутуу цаас, бэлдэц цаас, бийр, бэх гэх мэт/
- Уралдаанд оролцогчид үндэсний хувцастай ирнэ.

Уралдаанд оролцогчдыг 04 дүгээр сарын 22-нд ГИЦС-ийн Д.Пүрэвсүрэн багш бүртгэнэ. Холбогдох утас: 89014743

ДОЛОО. УРАЛДААНЫ ШАЛГАРУУЛАЛТ, ШАГНАЛ:

Уралдааны ангилал тус бүрт эхний 3 байр эзлүүлж, өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнаж урамшуулна.

ДУНДГОВЬ АЙМГИЙН ХЭЛНИЙ БОДЛОГЫН САЛБАР ЗӨВЛӨЛ
ГОВИЙН ИРЭЭДҮЙ ЦОГЦОЛБОР СУРГУУЛЬ